



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 221/А/1290319

Мандалговь

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитаар тайлант хугацаанд мэдээлэх 21 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т /Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна/, 3.1.4-т /Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага/ 4 дүгээр зүйлийн /Шилэн дансны зарчим/ 4.1.3-т /тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх/ заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т /Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө/, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь.

1. Шилэн дансны тухай хууль, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга нийтлэг стандарт тогтоосон журмын хэрэгжилтэд хяналт тавих, мэдээлэл байршуулах ажил хариуцсан ажилтны ажлын хариуцлагыг сайжруулах;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж, биелэлтийг 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар<sup>1</sup>т ирүүлэхийг Эрдэнэдалай сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга А.Соёл-Эрдэнэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

Т.ОЮУН-ЭРДЭНЭ

БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Р.МӨНХТОГТОХ

<sup>1</sup> Монгол Улс, Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 70593113



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 222/А/1240519

Мандалговь

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.


Аудитаар татварын орлогын төлөвлөгөөг 28.1 хувь буюу 279,710,600.00 /Хоёр зуун далан есөн сая долоон зуун арван мянга зургаан зуу/ төгрөгөөр тасалж, татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөний биелэлтийн хангах ажлыг хангалтгүй хэрэгжүүлсэн, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59.1.19-д /Нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах/, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т /Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх/, 41 дүгээр зүйлийн 41.2-т /Бүх шатны төсөв захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ/, 41.2.1-т /Хуулийн дагуу, улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухай төсвийн байгууллагын үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх/, Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.30-д /татварын улсын байцаагч гэж энэ хуулийн дагуу татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлж, татвар төлөгчид үйлчлэх, татвар хураах, тайлан хүлээн авах, хяналт шалгалт хийх чиг үүрэг бүхий татварын албанд ажилладаг, эрх олгогдсон төрийн захиргааны албан хаагчийг/ заасныг тус тус зөрчсөн байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т /Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө/ Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.10 заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Татварын болон татварын бус орлогыг төлөвлөхдөө тайлант оны онцлог, эдийн засгийн нөхцөл байдлын өөрчлөлт, өмнөх оны гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, орлогын нэр төрлийг бүрэн төвлөрүүлэх;
2. Сумын татварын алба буюу татварын байцаагч, татварын орлого бүрдүүлэлтэд хамаарах алба хаагч нарыг удирдлагаар хангаж, ажлын хариуцлагыг нь сайжруулан хууль тогтоомжид заасан эрх, үүргээ хэрэгжүүлэх.

Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар<sup>1</sup>т нотлох баримтын хамт ирүүлэхийг Эрдэнэдалай сумын Засаг дарга Б.Лхагвамандал, Санхүүгийн албан дарга А.Соёл-Эрдэнэ, Татварын байцаагч С.Зулцэцэг нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**  
АУДИТОР  Г.ОЮУН-ЭРДЭНЭ

**БАТАЛГААЖУУЛАН:**  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  МӨНХТОГТОХ



<sup>1</sup> Монгол Улс, Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 70592208